

**ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2023 оны 06 дугаар сарын 22-ны өдөр, Пүрэв гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-3

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 4-7

1.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 03 дугаар дүгнэлт /үргэлжлэв/ 4-7

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
Төсвийн байнгын хорооны
06 дугаар сарын 22-ны өдөр /Пүрэв гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 9 цаг 28 минутад Төрийн ордны “Жанжсин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Х.Баделхан, С.Ганбаатар, Б.Жавхлан, Ц.Сандаг-Очир;

Чөлөөтэй: Ц.Даваасүрэн;

Тасалсан: Ц.Анандбазар, Ж.Батсуурь, Х.Булгантуяа, Д.Өнөрболор.

**Нэг.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 03 дугаар дүгнэлт
/үргэлжлэв/**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Д.Нарантуяа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа нар байлцав.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 03 дугаар дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Б.Баттөмөр нар үг хэлэв.

Г.Тэмүүлэн: 1.Онцгой албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийн 4.1.5 дахь заалтад “газрын тосны үйлдвэрлэлийн дайвар бүтээгдэхүүн, керосин.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “... тэгш байдал, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5

Татгалзсан: 5

Бүгд: 10

50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ч.Хүрэлбаатар дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Тэмүүлэн: Улсын Их Хурлын гишүүн Ч.Хүрэлбаатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 3

Бүгд: 10

70.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Г.Тэмүүлэн: 1.Онцгой албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийн 4.1.5 дахь заалтад “газрын тосны үйлдвэрлэлийн дайвар бүтээгдэхүүн, керосин.”

гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "... тэгш байдал, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн." гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Онцгой албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийн 4.1.5 дахь заалтад "газрын тосны үйлдвэрлэлийн дайвар бүтээгдэхүүн, керосин." гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 4 дэх хэсгийн "Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна." гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Онцгой албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн хүснэгтийн 6 дахь заалтад "Газрын тосны үйлдвэрлэлийн дайвар бүтээгдэхүүн, керосин, 1 тонн" гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "... тэгш байдал, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн." гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Онцгой албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн хүснэгтийн 6 дахь заалтад "Газрын тосны үйлдвэрлэлийн дайвар бүтээгдэхүүн, керосин, 1 тонн" гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 4 дэх хэсгийн "Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна." гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Онцгой албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн хүснэгтийн 10 дахь заалтад "Газрын тосны үйлдвэрлэлийн дайвар бүтээгдэхүүн, керосин, 1 тонн, 285 000 төгрөг" гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "... тэгш байдал, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим

мөн.” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Онцгой албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн хүснэгтийн 10 дахь заалтад “Газрын тосны үйлдвэрлэлийн дайвар бүтээгдэхүүн, керосин, 1 тонн, 285 000 төгрөг” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 4 дэх хэсгийн “Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна.” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 9 цаг 45 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 17 минут үргэлжилж, 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр 9 цаг 45 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 06 дугаар сарын 22-ны өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”
танхим
9 цаг 28 минут.

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Тэмүүлэн: Байнгын хорооны гишүүддээ энэ өглөөний мэндийг хүргэе. Байнгын хорооны гишүүдийн олонх нь хүрэлцэн ирсэн байна. Байнгын хорооны хуралдаанд Ганибалын Амартүвшин, Жигжидийн Батжаргал, Лхагвын Мөнхбаатар, Салдангийн Одонтуяа, Бөхчулууны Пүрэвдорж, Шадарбалын Раднаасэд, Дуламдоржийн Тогтохсүрэн, Хүрэлбаатарын, Чимэдийн Хүрэлбаатар, Баттогтохын Чойжилсүрэн нар хүрэлцэн ирсэн байна. Ингээд 2023 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Байнгын байнгын хорооны хуралдаанаар нэг асуудал байгаа. Өчигдөр хэлэлцэж байсан Үндсэн хуулийн цэцийн 4 дүгээр дүгнэлтийг үргэлжлүүлэн хэлэлцэх асуудал байгаа. Ардчилсан намын бүлгээс завсарлага авсан. Байнгын хорооны зүгээс нэг хоногийн хугацаатай завсарлага өгсөн. Ингээд гишүүд асуулт асууж, хариулж авч дууссан. Горимын саналын дараа Цэцийн дүгнэлттэй холбогдуулаад үг хэлэх гишүүдийн нэрсийг авъя. Үг хэлэх гишүүд байна уу? Баттөмөр гишүүнээр тасаллаа. Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: Нэг зүйлийг сануулъя. Ер нь бол яг энэ төрлийн бизнес эрхэлдэг хүмүүс яг энэ асуудлаар үг хэлэх бүүр мөн түүнчлэн санал өгөх асуудал бол дэгээр бас ёс зүйн асуудлаар бас хориотой байдаг шиг санагдаж байна. Тийм учраас хэлж ярих үгээ бас бодох хэрэгтэй.

2 дугаарт нь Алтаниширээгийн нефть боловсруулах үйлдвэр

байгуулагдаж байгаа. Тэгээд энэ бол минийхээр бол 1,6 тэрбум доллароор л босох байх. Уул нь 1 тэрбумаар босно гэж явж байсан. 1,6 тэрбум доллароор босох байх. Тэгэх дээр энэ бол Монголын бас тодорхой ирээдүй юм. Бид нар цаанаас нь Тамсагаас Норинко компаниар юу хоолой татуулж байгаа. Тэгэхээр энэ үйлдвэр ашиглалтад орох юм бол бидний нефтийн асуудал бол нэлээн тийм сайн түвшинд очно гэж харж байгаа. Тэгэхээр Оросууд бол Монголыг бас энэ ялангуяа эрчим хүчний, бензин шатахууны тусгаар байдлын эсрэг бол байдаг гэдгийг бол бүгдээрээ мэднэ. Тийм учраас энэ керосин, нафта зэрэг 230 мянган тонныг авчраад, тэгээд яах вэ Замын-Үүд дээр юу 2 дээр нэг, нэг үйлдвэр жижижсэн үйлдвэр байгаа л даа. Тэр хоёр нь 15, нэг нь 20-иод хувийг нь нэрдэг, хольдог, нэг их нэрээд байхгүй хольдог. Үлдсэн тэр 65 хувийг нь тэр Чойр дээр зүгээр л ямар ч үйлдвэр байхгүйгээр хольж, энэ чинь холиод л тавьчихдаг юм шүү дээ. Тэрнээс нөгөө торхныхоо доор сэнс байлгаж байгаад л түүгээрээ эргүүлээд л хуйлруулаад л тэгээд л хольдог. Ямар ч стандарт бус ийм л юм байгаа.

Тэгээд энэний ард, энэ бизнесийн ард бол Оросын Швейцарын иргэшилтэй 3 Орос нөхөр байж байгаа. Тэгээд бид нар ингээд гадаадынхны хөл, гар хөл болоод байх юм уу? Бид нар Монголчуудыгаа ингээд хохироон, хохироон бүх машин тэргийг нь эвдэн, эвдэн, дээрээс нь үр хүүхдийг нь өвчлүүлэн, өвчлүүлэн энэ бизнесийг дэмжих юм уу? Яг энэ хууль батлагдах өдөр Ёндон сайдын хэлж байсан үгийг та нарт би сануулчихъя. Дэлхийн улс орон бүгдээрээ Евро-5 руу явж байна. Тэнд хүхэрлэгийн хэмжээ 10PPM, байдаг 10PPM байдаг. Гэтэл энэ шатахуун дээр чинь 4500 байгаа шүү дээ. 4500 хүхрийн. Энэ чинь хүхэр чинь ямар их аюултай юм, энэ нүүрснээс болоод ямар их хүүхдүүд хордож байгааг та нар бүгдээрээ мэдэж байгаа шүү дээ.

Тэгээд хүнд фракцаар нь тэр автобуснууд нь явдаг. 2 жилийн өмнө тэр замын хажуу талын гэрлийн шон 50

метрээс доош тас хар болчихсон л байдаг байсан шүү дээ. Одоо та нар мартчихсан. Арай гайгүй шатахуун хэрэглээд байгаа байхгүй юу. Тэгээд евро-5 10PPM байдаг. Гэтэл тэндээс 450 дахин илүү хорттой, хүхрийн хэмжээтэй ийм шатахууныг импортлох тэр зөвшөөрлийг та нар Монголын алаг үрсийн эсрэг л шийдвэр гаргах гэж байгаа шүү гэдгийг хэлье.

Г.Тэмүүлэн: Баттөмөр гишүүний микрофоныг өгье.

Б.Баттөмөр: Монгол Улс жилд 1,8 сая тонн нефть бүтээгдэхүүн импортлодог. 15 оноос эхлээд авто бензин 400 мянган төгрөг, дизелийн түлшинд 500 мянган төгрөгийн онцгой татвар төлж ирсэн. Шатахуун импортлодог энэ муу нэртэй компаниуд. Онцгой татварыг юунд оногдуулдаг вэ гэхээр зэрэг эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлдэг бүтээгдэхүүнд оногдуулдаг. 2016 оноос эхлээд газрын тосны завсрын бүтээгдэхүүний хэмжээ керосин 10 дахин, хүнд фракцын импорт 47 дахин нэмэгдсэн. 15-аас 21 онд 822 мянган тонн ийм завсрын бүтээгдэхүүн оруулж ирсэн. Монгол Улсын шатахууны нэг жилийн импортын 46 хувийг энэ хольцыг оруулж ирдэг компаниуд оруулж ирсэн байгаа юм.

Онцгой албан татвараар улсын төсөвт орох хохирол алдагдсан боломж 198 тэрбум төгрөг, бараг 200 тэрбум төгрөг болчихсон. Энэ ҮХЦ-ийн дүгнэлтэд Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 1.2-т заасан тэгш байдал гэдэгтэй нийцэх үү? Нэг хэсэг нь төлөөд байдаг, нэг хэсэг нь төлдөггүй. Дээр нь НӨАТ болон бусад албан татваруудын зөрүү гээд тэгэхэд бас дахиад зуугаад тэрбум. Ингээд 300 тэрбум төгрөг Монгол Улсын төсөвт орох боломж алдагдчихсан. Манайхаас бусад оронд бол үүнийг шатахуун хийгээд ингээд зарсан тохиолдолд бол буцаж нөхөж төлүүлэх ёстой. Тэгтэл одоо энийг Үндсэн хууль зөрчсөн болдог энэ дээр нь төр зохицуулаад татвар тогтоохоор. Энийг татвар хураадаг манай Сангийн яам энэ хаана нь байсан юм бэ? Үүргээ гүйцээж

чадаагүй байна шүү дээ. Завсрын бүтээгдэхүүн алкилат, тэр нафта, керосин, энэ хүнд фракцын түлш гэж байдаг. Энийг зөвхөн боловсруулах үйлдвэрт л боловсруулж бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг.

Гэтэл Монголд боловсруулах үйлдвэр байхгүй. Үндэсний аудитын газрын 2022 оны аудитын тайлангийн 2 дугаар хавсралтад Монголд энэ газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ гэж 22 ААН тусгай зөвшөөрөл авсан байдаг юм байна. Үүнээс нэг ч компани үйлдвэр байхгүй. Энэ би баримттай ярьж байгаа шүү. Энэ дотор энэ хольдог Лекс ойл гэдэг компани заргалдаад байгаа компанид үйлдвэр байхгүй гээд цагаан дээр хараар биччихсэн байгаа шүү. Үйлдвэр байхгүй. Үйлдвэрлэлийн зөвшөөрлийг яагаад олгосон бэ гэхээр зэрэг төслөөр нь олгогчидоог. Энэ үйлдвэр дээр хэн ч очиж үзээгүй. Ийм л ажил л бай хийж байна л даа Монголчууд.

Нефтэд байдаг тэр хүний эрүүл мэндэд асар хорттой хар тугалга, хүхрийн агууламжийг тодорхойлох шинжилгээ өнөөдөр нэг ч удаа хийгдээгүй. Энэ хольж хуурамч шатахуун хийдэг ажил дэлхийн хамгийн хоцрогдсон төр засаг нь ажлаа хийдэггүй, авлигад идэгдсэн, эзэнгүй, ядуу, хуучин техник ихээр хэрэглэдэг орнуудад очиж ашиглаад, хөөгддөг. Хондурас, Гватемал, Киргизээс хөөгдөөд 2016 оноос Монголд ажиллаад, 7 жил цэцэглээд, одоо дахиад манай ҮХЦ-ийн дэмжлэгтэйгээр улам цэцэглэх нь л дээ. Ийм технологиор хэрэглэсэн шатахуун хэрэглэдэг улс дэлхийд Монголоос өөр хаана ч байхгүй шүү. Энэ хорттой хулгайн бизнесийг ядуу буурай орнууд хэрэгжүүлдэг ОХУ-ын харьяалалтай энэ салбарт ажиллаж байсан авлигал өгч ажлаа бүтээдэг, бусдын гараар могой бариулдаг мэргэшсэн 1 Орос хулгайч байгаа. 3 ч биш ээ Пүрэвдорж гишүүн, 1 хулгайч байгаа. Энэ нөхрийн асуудал бол гарч ирэх юм байна лээ. Энэ нөхөр бол яадаг вэ гэхээрээ зэрэг гадна дотоодын ядуу буурай орнуудад очиж худалдаж авдаг, авлигал өгдөг ийм л нөхөр.

Тэгээд энэ нефтийн зах зээл гэдэг бол үндэсний аюулгүй байдалд үнэхээр шууд нөлөөтэй ийм салбар шүү. Найруулдаг энэ компани тэрбумаар тоологдох энэ их мөнгийг хаанаас олж ирж байгаа юм бэ? Дөчөөд насны залуу бизнес хийж байгаагүй. Шударгаар ийм бизнес босгох мөнгө байхгүй шүү дээ. Энэ бол угаагдаж байгаа мөнгө шүү нөхдөө. Төсвийн байнгын хорооныхон та нар үзээрэй. Бид хар жагсаалтаас нэг юм гараад, дахиад одоо хар жагсаалтаасаа бүрэн гараагүй байна. Хяналттай орнуудын жагсаалтад байгаа. Дахиад тэр лүүгээ явчих вий дээ. Асар олон сэжигтэй гүйлгээнүүд байдаг юм байна лээ шүү нөхдөө.

Энэ ашиг сонирхлын зөрчил гээд нэг юм яриад байгаа юм. Монголд 300 гаран ААН зөвшөөрөлтэй. 30 гаруй компани идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг. Бүгд татвараа төлдөг. 300 вагоныг өнөөдөр төмөр зам дээр 2 сар зогсоож байгаад, 2 сар зогсоож байгаад ҮХЦ-ээр Цэцийн шийдвэр гаргуулж байгаад өнөөдөр гаалийн бүрдүүлэлт хийгээд татваргүй авч байна шүү дээ. Ямар бяртай байна вэ, ингэж болдог юм уу? Би Монголын ард түмний эрх ашгийн үүднээс ярьж байгаа шүү. Би юунаас ч айхгүй энд. Нэг нүүрсний хулгайч гээд нөгөө хулгайчууд юманд холбогдуулдаг шиг холбогдуулна л биз. Надад би хулгай хийдэггүй. Ийм байж болохгүй шүү дээ. Энийг нефтийн компаниуд санаачлаагүй. Пүрэвдорж гишүүн санаачилсан. Бид нар бүгдээрээ дэмжсэн шүү дээ. Яагаад өнөөдөр бүгдээрээ ингээд энэ компанийн талд ороод бүгд гараа өргөөд, сая Хууль зүйн байнгын хороон дээр бүгд гараа өргөөд л ингээд л дэмжиж байлаа шүү дээ.

Монголын ард түмний төлөө, Монголын ард түмний эсрэг хийж байгаа хүнд гэмт хэрэг шүү. НҮБ-ын тэр Хүний эрхийн конвенцын маш олон заалтыг зөрчиж байгаа юм. Хамгийн хоцрогдсон орнуудад энийг ингэж хэрэглэдэг. Ийм байгаа шүү.

Г.Тэмүүлэн: Цэцийн дүгнэлттэй холбогдуулж гишүүд үг хэлж дууслаа. Санал хураалтыг явуулж эхэлье.

1.Онцгой албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийн 4.1.5 дахь заалтад “газрын тосны үйлдвэрлэлийн дайвар бүтээгдэхүүн, керосин.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “... тэгш байдал, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалтыг явуулъя. Санал хураалт. Хүрэлбаатар сайдад микрофон өгье.

Ч.Хүрэлбаатар: Миний кноп ажилласангүй сая, дахиад санал хураалгаж өгөөч.

Г.Тэмүүлэн: Хүрэлбаатар сайдын саналаар техникийн нөхцөл байдлаас шалтгаалаад санал хураалтыг дахин явуулъя гэсэн саналаар хүчингүй болгох санал хураалтыг явуулъя. Санал хураалт. Хүчингүй болгох санал 70 хувиар дэмжигдлээ. Хүрэлбаатар сайдын санал дэмжигдсэн учраас саяын уншсан томъёоллоор санал хураалтыг дахин явуулъя. Санал хураалт. Санал хураалт 60 хувиар дэмжигдлээ.

2.Онцгой албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийн 4.1.5 дахь заалтад “газрын тосны үйлдвэрлэлийн дайвар бүтээгдэхүүн, керосин.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 4 дэх хэсгийн “Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна.” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалтыг явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 10 гишүүн оролцож 60 хувиар дэмжигдлээ.

3.Онцгой албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн хүснэгтийн 6 дахь заалтад “Газрын тосны үйлдвэрлэлийн дайвар бүтээгдэхүүн, керосин, 1 тонн” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “... тэгш байдал, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалтыг явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 10 гишүүн оролцож 6 гишүүн дэмжиж, 60 хувиар дэмжигдлээ.

4.Онцгой албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн хүснэгтийн 6 дахь заалтад “Газрын тосны үйлдвэрлэлийн дайвар бүтээгдэхүүн, керосин, 1 тонн” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 4 дэх хэсгийн “Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна.” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалтыг явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 10 гишүүн оролцож, 6 гишүүн дэмжиж 60 хувиар дэмжигдлээ.

5.Онцгой албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн хүснэгтийн 10 дахь заалтад “Газрын тосны үйлдвэрлэлийн дайвар бүтээгдэхүүн, керосин, 1 тонн, 285 000 төгрөг” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “... тэгш байдал, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалтыг явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 10

гишүүн оролцож, 6 гишүүн дэмжиж 60 хувиар дэмжигдлээ.

6.Онцгой албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн хүснэгтийн 10 дахь заалтад “Газрын тосны үйлдвэрлэлийн дайвар бүтээгдэхүүн, керосин, 1 тонн, 285 000 төгрөг” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 4 дэх хэсгийн “Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна.” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалтыг явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 10 гишүүн оролцож, 6 гишүүн дэмжиж 60 хувиар дэмжигдлээ. Санал хураалтыг явуулж дууслаа. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 4 дүгээр дүгнэлтийг хэлэлцэж дууслаа. Ингээд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 4 дүгээр дүгнэлтийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд миний бие өөрөө танилцуулъя даа.

9.45 цаг

Ингээд Төсвийн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хаасныг мэдэгдье. Гишүүдэд баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ Д.УЯНГА

